



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 6/971

Улаанбаатар хот

У.Сарантуяаг ажлаас чөлөөлж, нэг удаагийн
буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7, 271¹.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Замын-Үүд дэх гаалийн газрын эрүүл ахуй, стандартын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч Ухнагийн Сарантуяаг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. У.Сарантуяад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 25 479 650 / хорин таван сая дөрвөн зуун далан есөн мянга найман зуун тавин/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.
3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа У.Сарантуяагийн гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Замын-Үүд дэх гаалийн газар /О.Цэенрэгзэн/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 3110